



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/162

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймагт covid 19-ын тохиолдол бүртгэгдэж Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан PCR, түргэвчилсэн оношлуур, шинжилгээ хийлгэж буй иргэний мэдээллийг онлайн бүртгэх пос машин авах зардалд зориулж 17 026 650 /арван долоон сая хорин зургаан мянга зургаан зуун тавин/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдэлээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч /Ц.Чогсомжав/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

03 Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын өдрийн А/7/62
дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулагын тооцоо

№	Зардлын үйл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1.	Пос машин	1	2 010 000	2 010 000
2.	Түргэвчилсэн оношлуур	345	25850	8 918 250
3	PCR шинжилгээний оношлуур	21	290 400	6 098 400
				17 026 650